



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/90 -

Улаанбаатар хот

### Баянгол дүүргийн Боловсролын хэлтсийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2,486,345.00 (хоёр сая дөрвөн зуун наян зургаан мянга гурван зуун дөчин тав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвд балансаас баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс (Б.Пүрэвжал)-д зөвшөөрсүгэй.
2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 13 дугаар цэцэрлэг (Б.Номиндалай)-т даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА





Балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс

| №                                    | Эд хөрөнгийн нэр | Марк үзүүлэлт | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Ашиглалтад авсан он | Нэгж үнэ     | Нийт үнэ     | Байгуулсан элэгдэл /2025.05.31/ | Нийт үлдэгдэл       | Шилжүүлэн авах байгууллага          |
|--------------------------------------|------------------|---------------|-------------|------------|---------------------|--------------|--------------|---------------------------------|---------------------|-------------------------------------|
| 1                                    | Смарт дэлгэц     | Haier         | ш           | 1          | 2024.12.31          | 2,486,345.00 | 2,486,345.00 | 258,994.25                      | 2,227,350.75        | Баянгол дүүргийн 13 дугаар цэцэрлэг |
| <b>Машин, тоног төхөөрөмжийн дүн</b> |                  |               |             |            |                     |              |              | <b>258,994.25</b>               | <b>2,227,350.75</b> |                                     |